

Номын сангийн алсын хараа

Тайлангийн хураангуй
10 Үндсэн чиглэл, Боломж



190



НҮБ-ын гишүүн улс

469,152



жилийн номын
сангийн туршлага

Бүх



төрлийн номын сан,
үе үеийн төлөөлөл

9,291



оролцогч

185



ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

21,772



цахим санал



IFLA
Global Vision

Гол дүгнэлт

Бид дэлхий даяар үнэт зүйл зорилгоороо нэгддэг.

Дэлхийн бүс нутгуудад бүх төрлийн номын сан ажлын туршлагатаа номын сангийн тогтвортой үнэ цэн, үүргийг тэргүүлэх итгэл үнэмшил, чиг зорилгоо болгодог.

Бид дэлхий дахины болон орон нутгийн түвшний номын сангийн үйл ажиллагааг үр дүнтэй хослуулах ёстой.

Номын сангийн салбарт тулгамдаад буй нийтлэг асуудлуудыг шийдэхэд салбарын түвшинд нэгдэх, цаашдын үйл ажиллагаанд орон нутгийн онцлог, шаардлагуудыг тусгах нь зайлшгүй чухал.

10 Үндсэн чиглэл

- 1. Бид мэдлэг мэдээллийг үнэ төлбөргүй, тэгш хүртээхийн төлөө ажимадаг**

Мэдлэг, мэдээллийг үнэ төлбөргүй, тэгш хүртээх явдал нь номын сангийн салбарын хамгийн чухал үнэ цэн, итгэл үнэмшил юм.
- 2. Бидний үндсэн үүрэг бол бичиг үсэгт тайлагдах, унших, суралцахыг дэмжих**

Бидний бичиг үсэгт тайлагдах, унших, суралцахыг дэмжих уламжлалт үүргийг дэлхийн номын сангуудын зорилгыг биелүүлэхэд нэн чухал гэж үзсэн байна.
- 3. Бид олон нийтэд үйлчлэхэд гол анхаарлаа хандуулдаг**

Бид олон нийт, хэрэглэгч гэдгийг юу гэж тодорхойлохоос үл хамааран үйлчлүүлэгчдийнхээ эрэлт хэрэгцээг хангахын төлөө хүчин зүтгэдэг. Бид нийгмийн олон төрлийн бүлгийг чухалчилж, тэдгээрийг номын сангийн үйлчилгээнд тэгш хамруулах, ашгийн төлөө бус, нийтийн зай талбайг бий болгохыг нэн тэргүүнд тавьдаг.
- 4. Бид цахим шинэчлэлийг чухалчилдаг**

Олон нийтийн техник технологи ашиглах чадвараас үл хамааран нийгмийн амьдралыг сайжруулах, номын сангийн үүргийг биелүүлэхэд цахим шинэчлэл нэн чухал гэдэгтэй салбар даяараа санал нэгдсэн байна.

10 Боломж

- 1. Бид оюуны эрх чөлөөг хөхиүлэн дэмжих ёстой**

Мэдлэг мэдээллийг үнэ төлбөргүй, тэгш хүртээх нь үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэхэд тулгуурладаг. Энэ хэрэгцээг хангахад оруулах номын сангийн үүргийг улам илүү сурталчлан таниулах хэрэгтэй.
- 2. Цахим эринд бид уламжлалт үүрэг, үйл ажиллагаагаа шинэчлэх ёстой**

Цахим эринд бичиг үсэгт тайлагдах, унших, суралцахыг дэмжихийн тулд номын сангууд тасралтгүй шинэчлэгдэн хөгжих ёстой. Уншигчдын зогсолтгүй хувьсах эрэлт хэрэгцээг хангахад чиглэн номын сангийн үйлчилгээ, сан хөмрөг, үйл ажиллагааг хөгжүүлэх, шинэчлэх шаардлагатай.
- 3. Бид олон нийтийн эрэлт хэрэгцээг гүнзгий мэдэрч, амьдралд нь нөлөөлөхүйц үйлчилгээг бий болгох ёстой**

Номын сангийн олон нийтэд чиглэсэн үйл ажиллагааг сайжруулах нь орон нутгийн түвшний хамтрагчидтай холбоо тогтоох, номын сангийн үйлчилгээг төдийлөн хүртэж чаддаггүй нийгмийн хэсэгт хүрч үйлчлэх, хүний амьдралд мэдэгдэхүйц нөлөө үзүүлэхэд тус дөхөм болно.
- 4. Бид техник технологийн байнгын хувьсал өөрчлөлттэй хөл нийлүүлэх ёстой**

Цахим хувьсгалын олгож буй боломжуудыг бүрэн дүүрэн ашиглах чадвар чадамж, төсөв санхүү, дэд бүтэц, техник хэрэгслийг бүрдүүлэх нь бүх номын сангийн нэн чухал хэрэгцээ болоод байна.

5. Бид салбарынхаа эрх ашгийг хамгаалах эрэлт хэрэгцээг мэдэрдэг манлайлагчидтай

Номын сангийн удирдлагууд манлайлагч, нэр нөлөө бүхий хүмүүс, олон нийттэй хамтарч салбарынхаа эрх ашгийг хамгаалахыг тэргүүлэх чиглэлээ болгодог.

6. Бидний өмнө тулгамдаж буй асуудлуудын нэг нь төсөв санхүү
Уншигч үйлчлүүлэгчдийн эрэлт хэрэгцээг хангахуйц үйлчилгээ үзүүлэх нэг чухал үзүүлэлт бол номын сангийн нөөцийг бүрдүүлж, үр нөлөөнд чиглэсэн зүй зохистой хуваарилалтыг бий болгох явдал юм.

7. Бид хамтын ажиллагаа, түншлэлийг бий болгохыг эрхэмлэдэг
Номын сан хоорондын хамтын ажиллагаа болон гадаад түншлэлийг хөгжүүлэх нь хүчирхэг, нэгдмэл номын сангийн салбар бий болгох чухал хүчин зүйл.

8. Бид өөрчлөгдөж шинэчлэгддэггүй, хөшүүн хойрго байдал, хүнд суртлаас зайлсхийхийг эрмэлздэг
Салбарын хэмжээнд хоцрогдсон, явцуу туршлагуудыг халж, өөрчлөлт шинэчлэлд нээлттэй, идэвх санаачлагатай, тэргүүлэгч хандлагыг чухалчилж байна.

9. Бид дэлхийн өв соёлын хадгалагч хамгаалагч
Номын сан дэлхийн баримтат өв болон тэдгээрийн агуулсан бүтээлч санаа, мэдлэгийн үндсэн сан юм. Бид хойч үедээ мэдлэг мэдээллийг системтэй хадгалж хамгаалан, өвлүүлэхдээ мэргэшсэн.

10. Бидний залгамж халаа, залуу мэргэжилтнүүд ажил мэргэжилдээ эзэн байж, салбараа манлайлах чин хүсэлтэй байна
Салбарын залуу мэргэжилтнүүдийн идэвхтэй оролцоо ирээдүйн номын сангийн салбарын хөгжлийг тодорхойлоход хүчин зүтгэх чин хүслийн илэрхийлэл болж байна.

5. Бидэнд салбарын бүх түвшинд дуу хоолойгоо илэрхийлэх хамгаалагчид хэрэгтэй байна

Номын сангийн салбарт ажиллаж буй хүн бүр салбарын үнэлэмжээ дээшлүүлэх, зорилго зорилтоо биелүүлэхэд дуу хоолойгоо нэгтгэн эрх ашгаа хамгаалахын ач холбогдлыг ойлгох ёстой. Номын санч бүр салбарынхаа хамгаалагч мөн!

6. Бид үнэ цэн, үр нөлөөгөө оролцогч талуудад ойлгуулахыг чухалчлах ёстой
Номын сангийн үр өгөөж, нөлөөлийн талаарх бодит жишээнүүдийг гаргаж тавих нь шийдвэр гаргагчдын дэмжлэгийг авах чухал хөшүүрэг болно.

7. Бид хамтран ажиллах ухамсрыг төлөвшүүлэх ёстой
Хамтран ажиллахад тулгардаг бодит хийгээд хийсвэр саад бэрхшээлүүдийг танин мэдэж, шийдвэрлэх нь салангид тусдаа ажилладаг хандлагыг халж, нэгдмэл номын сангийн салбарын үнэт зүйлийг цогцлооход хувь нэмэр оруулна.

8. Бид өнөөгийн бүтэц, хандлагаа шинэчлэх шаардлагатай
Идэвх санаачлагагүй байдлаа халж, өөрчлөлт шинэчлэлттэй хөл нийлүүлэх нь номын сангийн өмнө тулгамдаад буй асуудлуудыг шийдвэрлэх гарц болно.

9. Бид дэлхийн баримтат өвийн хүртээмжийг нэмэгдүүлэх шаардлагатай
Бид сан хөмрөгт буй өвүүдээ түгээн дэлгэрүүлэхэд тулгардаг санхүүгийн болон эрх зүйн асуудлуудыг шийдэхэд дуу хоолойгоо нэгтгэн, сан хөмрөг, мэргэшил, нөөц бололцоогоо солилцох, шинэ туршлага, арга замуудыг нэвтрүүлэх боломжийг салбар даяар бүрдүүлэх ёстой.

10. Бид залуу мэргэжилтнүүдэд сурах, хөгжих, манлайлах өргөн боломжийг олгох ёстой
Номын сангийн салбар залуу мэргэжилтнүүдийг хөгжүүлэх, хооронд нь холбох, тэдний шинэ тутам хэрэгцээг хангах чадамжтай байж, тэдэнд ирээдүйн удирдагч байх боломжийг бүрдүүлэх ёстой.

Бидний алсын хараа, Бидний ирээдүй:

Хүчирхэг нэгдмэл номын сангийн салбар бичиг үсэгт тайлагдсан, мэдлэг мэдээлэл, идэвх оролцоотой нийгмийг бүтээхэд үнэтэй хувь нэмэр оруулна.

Улам бүр даяарчлагдсаар буй энэ эрин үед номын сангийн салбарт тулгараад буй асуудлуудыг даван туулах цорын ганц арга зам бол нийтийг тэгш хамарсан, дэлхий дахины номын сангуудын нэгдмэл, хамтын шийдлүүд юм.

Иймийн тул Олон Улсын Номын Сангийн Холбоо (ОУНСХ)-оос нэгдмэл номын сангийн салбарын хэтийн төлөвлөгөөг гаргахаар “Номын сангийн алсын хараа” хэлэлцүүлгийг дэлхий дахинд эхлүүлсэн билээ.

Өмнө нь үүн шиг номын санч бүрт дэлхий нийтийг хамарсан нэгдсэн нэг хэлэлцүүлэгт хувь нэмэр оруулах боломж олгож, ийм олон номын санч дэлхийн өнцөг булан бүрээс дуу хоолойгоо нэгтгэсэн тохиолдол байгаагүй юм.

2017 онд ОУНСХ дэлхийн номын сангийн салбарын бэрхшээл хийгээд боломжуудыг судлан таних ажлыг эхлүүлж, 7 тивийн НҮБ-ын гишүүн 190 улсаас ирүүлсэн тайлангаас бид дэлхий даяар зорилго, үнэт зүйлсээрээ нэгддэг нь харагдсан. Гэвч дэлхий дахины болон орон нутгийн түвшний номын сангийн үйл ажиллагааг үр дүнтэйгээр хослуулах ёстой бөгөөд номын сангийн салбарт тулгамдаад буй нийтлэг асуудлуудыг шийдэхэд салбарын түвшинд нэгдэх, цаашдын үйл ажиллагаанд орон нутгийн онцлог, шаардлагуудыг тусгах нь зайлшгүй чухал юм.

Энэ 2018 онд ОУНСХ-оос өөрийн хэтийн төлөвлөгөө, номын санчдад үлгэр жишээ эх сурвалж болохуйц үйл ажиллагаа, туршлагуудыг багтаасан санааны нөөц санг бүтээхээр ажиллаж байна. Цуврал хэлэлцүүлгүүд, цахим сүлжээгээр дамжуулан дэлхийн номын санчдын санал санаачилгыг нэгтгэхийг зорьж байна. Ингэснээр бидэнд бүс нутгийн түвшний бүх номын сан ямар үүрэг хүлээхийг тодорхойлох боломж бүрдэнэ. Та бүхний ирүүлсэн санал санаачилгаар ОУНСХ хүчирхэг нэгдмэл номын сангийн салбар бичиг үсэгт тайлагдсан, мэдлэг мэдээлэл, идэвх оролцоотой нийгмийг бүтээх хэтийн зорилгоо бодит үйл хэрэг болгох стратеги болон ажлын төлөвлөгөөгөө гаргах болно.



#iflaGlobalVision

ifla.org/globalvision